



## БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2023/180/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Булган аймаг  
2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ

Утас: **7034-2580**

Цахим хаяг: [erdeneb@audit.gov.mn](mailto:erdeneb@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: **7034-2716**

Цахим хаяг: [enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:enkhtsoodolj@audit.gov.mn)

ЦЭСБ аудит ХХК-ийн захирал: Ч.Цэрэннадмид

Утас: **9511-2689**

Цахим хаяг: [tseb.audit@gmail.com](mailto:tseb.audit@gmail.com)

Аудитор Ш.Ганчимэг

Утас: **99377360**

Цахим хаяг: [shagdarganchimeg44@jmail.com](mailto:shagdarganchimeg44@jmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт .....
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
  - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....
  - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин .....
  - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....
  - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .....
4. Аудитын тайлан .....

  - 4.1 Ерөнхий зүйл .....
  - 4.2 Материаллаг байдал .....
  - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
  - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....
  - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....
  - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....

5. Аудитын илрүүлэлт .....
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус байгууллагын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс 489,068.0 мянга, Орхон сумын нөхөн сонгуулийн үйл ажиллагаанд 7,673.4 мянган төгрөг санхүүжүүлэхээр баталснаас нийт зардлын гүйцэтгэл 95.1 хувьтай хэрэгжжээ.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас хөрөнгө худалдан авахад 19,824.0 мянган төгрөг санхүүжилт олгосон ч хөрөнгийг бэлтгээгүй тайлант онд авлагаар бүртгэсэн байна.

**Аудитын гол асуудал**

Тус байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал байхгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан УБЕГ-ын даргаар батлуулж ажиллажээ. Хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 5 зорилтын 30 ажил, арга хэмжээг зохион байгуулан хэрэгжүүлж, гүйцэтгэлийн тайлангаар 88.5 хувиар дүгнэгдсэн байна. Цахим гарын үсгийн тухай хуулийн дагуу 9406 иргэнд тоон гарын үсэг олгож, иргэний улсын бүртгэлийн 4712, хуулийн этгээдийн 966, эд хөрөнгийн 1885 улсын бүртгэлийн үйлчилгээг тус тус үзүүлжээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	үлдэгдэл	ГҮЙЦЭТГЭЛ
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>59,160,930.50</b>	<b>74,348,155.70</b>
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	0.00	0.00
27	АВЛАГА	-	19,824,000.00
34	Бусад авлага	-	19,824,000.00
35	Байгууллагаас авах авлага	-	19,824,000.00
60	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>59,160,930.50</b>	<b>54,524,155.70</b>
61	Түүхий эд материал	12,547,724.60	13,176,684.80
62	Тусгай зориулалттай материал	12,547,724.60	13,176,684.80
65	Бэлэн бүтээгдэхүүн	1,980,614.10	6,151,729.10
66	Хангамжийн материал	44,632,591.80	35,195,741.80
67	Бичиг хэргийн материал	3,302,590.00	1,956,890.00
68	Аж ахуйн материал	23,147,671.80	16,647,671.80
69	Сэлбэг хэрэгсэл	3,419,500.00	4,063,500.00
73	Бусад хангамжийн материал	14,762,830.00	12,527,680.00
86	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>193,419,956.91</b>	<b>161,284,305.33</b>
106	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>193,419,956.91</b>	<b>161,284,305.33</b>
108	Биет хөрөнгө	193,419,956.91	161,284,305.33
111	Авто тээврийн хэрэгсэл	29,300,000.00	29,300,000.00
112	Хуримтлагдсан элэгдэл	(29,300,000.00)	(29,300,000.00)
113	Машин, тоног төхөөрөмж	253,351,492.40	244,223,870.85
114	Хуримтлагдсан элэгдэл	(60,803,535.33)	(89,935,565.28)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	23,809,806.00	15,647,195.00
116	Хуримтлагдсан элэгдэл	(22,937,806.16)	(8,651,195.24)
122	Бусад үндсэн хөрөнгө	-	(0.00)
127	Програм хангамж	5,593,800.00	5,593,800.00
128	Хасагдуулга	(5,593,800.00)	(5,593,800.00)
137	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>252,580,887.41</b>	<b>235,632,461.03</b>
138	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	0.00	213,114.92
139	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	213,114.92
164	Өглөг	0.00	213,114.92
165	Ажиллагчидтай холбогдсон өглөг	0.00	132,594.92
166	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	80,520.00
214	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>252,580,887.41</b>	<b>235,419,346.11</b>
215	Засгийн газрын хувь оролцоо	252,580,887.41	235,419,346.11
223	Хуримтлагдсан үр дүн	252,580,887.41	235,419,346.11
224	Өмнөх үеийн үр дүн	252,580,887.41	252,580,887.41
225	Тайлант үеийн үр дүн	-	(17,161,541.30)
231	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН</b>	<b>252,580,887.41</b>	<b>235,632,461.03</b>

Булган аймаг дахь Төрийн аудитын газар

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>455,991,532.00</b>	<b>519,221,969.87</b>
	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>49,603,232.00</b>	<b>17,480,569.87</b>
	Нийтлэг татварын бус орлого	49,603,232.00	17,480,569.87
	Төсөвт байгууллагын өөрийн орлого	49,603,232.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	49,603,232.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	8,031,984.87
120018	Үнэ төлбөргүй хүлээж авсан орлого-Бараа материал	-	9,448,585.00
	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>406,388,300.00</b>	<b>501,741,400.00</b>
	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>340,338,900.00</b>	<b>489,068,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	340,338,900.00	489,068,000.00
	Нэмэлт санхүүжилтийн орлого	66,049,400.00	12,673,400.00
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	-	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	66,049,400.00	7,673,400.00
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</b>	<b>418,792,780.26</b>	<b>529,715,176.72</b>
	УРСГАЛ ЗАРДАЛ	418,792,780.26	529,715,176.72
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>418,792,780.26</b>	<b>523,626,706.48</b>
<b>2101</b>	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>265,511,897.38</b>	<b>364,815,994.57</b>
210101	Цалин	209,196,901.11	289,233,691.61
210102	Нэмэгдэл цалин	50,888,234.39	68,398,203.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,426,761.88	7,184,099.50
<b>2101</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>36,440,964.53</b>	<b>54,693,976.73</b>
2101201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	26,032,781.92	44,564,737.73
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,640,385.06	2,347,371.72
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,112,488.13	2,589,638.21
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	528,196.95	568,093.64
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,127,112.47	4,624,135.43
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9,335,288.50	24,463,382.98
210301	Гэрэл цахилгааны зардал	565,621.00	1,008,949.38
210302	Түлш, халаалтын зардал	8,769,667.50	23,454,433.60
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>27,806,900.00</b>	<b>25,167,310.40</b>
210401	Бичиг хэргийн материал	4,012,700.00	8,391,500.00
210402	Тээвэр, шатахууны зардал	1,009,600.00	2,606,600.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	1,287,400.00	2,050,860.40
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	-	25,000.00
210406	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	21,497,200.00	12,093,350.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>313,000.00</b>	<b>1,038,000.00</b>
210601	Багаж хэрэгсэл	77,000.00	502,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	236,000.00	307,300.00
210604	Урсгал засвар	-	228,700.00
2107	Томиллолт, зочны зардал	36,000.00	-

210702	Дотоод томилолтын зардал	36,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж</b>	<b>5,345,167.25</b>	<b>6,041,559.80</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	196,000.00	807,500.00
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээний төлбөр	119,950.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	117,575.00	100,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	-
210809	Улсын мэдээллийн маягтын зардал	4,889,642.25	4,528,909.80
<b>2201</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>74,003,562.60</b>	<b>47,406,482.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	66,049,400.00	7,129,500.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	556,500.00	277,680.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,397,662.60	39,999,302.00
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	6,088,470.24
2103	Бусад урсгал шилжүүлэг	-	915,000.00
2103209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	915,000.00
	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	5,173,470.24
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	5,173,470.24
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	37,198,751.74	(10,493,206.85)
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	5,195,230.00	6,668,334.45
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	4,985,230.00	168,334.45
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	210,000.00	6,500,000.00
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(5,195,230.00)	(6,668,334.45)
	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	32,003,521.74	(17,161,541.30)

Булган аймаг дахь Төрийн аудитын газар

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>330,363,877.00</b>	<b>594,763,905.68</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>56,574,077.00</b>	<b>93,022,505.68</b>
120	Нийтлэг татварын бус орлого	56,574,077.00	93,022,505.68
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	56,574,077.00	93,022,505.68
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	56,574,077.00	93,022,505.68
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>273,789,800.00</b>	<b>501,741,400.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	207,740,400.00	489,068,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	207,740,400.00	489,068,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	66,049,400.00	12,673,400.00
131103	ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс	-	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	66,049,400.00	7,673,400.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)</b>	<b>328,688,548.50</b>	<b>594,763,905.68</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	328,688,548.50	594,763,905.68
<b>210</b>	<b>БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>272,965,580.50</b>	<b>495,652,929.76</b>
<b>2101</b>	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>168,895,600.00</b>	<b>364,683,399.65</b>
210101	Үндсэн цалин	126,862,403.73	289,101,096.69
210102	Нэмэгдэл	38,586,434.39	68,398,203.46
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,446,761.88	7,184,099.50
<b>2102</b>	<b>Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>23,949,600.00</b>	<b>54,693,976.73</b>
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	17,233,200.00	44,564,737.73
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,678,800.00	2,347,371.72
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,343,400.00	2,589,638.21
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	336,000.00	568,093.64
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,358,200.00	4,624,135.43
<b>2103</b>	<b>Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал</b>	<b>9,282,065.50</b>	<b>24,463,382.98</b>
210301	Гэрэл цахилгааны зардал	512,398.00	1,008,949.38
210302	Түлш, халаалтын зардал	8,769,667.50	23,454,433.60
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>3,518,390.00</b>	<b>14,282,640.40</b>
210401	Бичиг хэрэг	1,399,110.00	7,006,500.00
210402	Тээвэр, шатахуун	769,600.00	2,606,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	881,280.00	1,970,340.40
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	25,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	468,400.00	2,674,200.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>140,000.00</b>	<b>22,749,800.00</b>
210601	Багаж техник хэрэгсэл	77,000.00	21,720,500.00
210603	Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл	63,000.00	687,300.00
210604	Урсгал засвар	-	342,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>36,000.00</b>	-
210702	Дотоод албан томилолт	36,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>455,525.00</b>	<b>1,512,650.00</b>

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	196,000.00	807,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	119,950.00	64,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	117,575.00	100,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>66,688,400.00</b>	<b>13,267,080.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	66,049,400.00	12,673,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	639,000.00	593,680.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>55,722,968.00</b>	<b>99,110,975.92</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	915,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	-	915,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	55,722,968.00	98,195,975.92
<b>213303</b>	<b>Төвлөрүүлэх шилжүүлэг</b>	<b>-</b>	<b>5,173,470.24</b>
<b>213306</b>	<b>Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг</b>	<b>55,722,968.00</b>	<b>93,022,505.68</b>
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	1,675,328.50	0.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,675,328.50	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	60.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,675,388.50	0.00

Булган аймаг дахь Төрийн аудитын газар

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>C0 1</b>	<b>2021 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл</b>			<b>95,693,935.77</b>	<b>95,693,935.77</b>
C0 7	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/		0	32,003,521.74	32,003,521.75
<b>C0 8</b>	<b>2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>			<b>252,580,887.41</b>	<b>252,580,887.41</b>
<b>D0 1</b>	<b>2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>			<b>252,580,887.41</b>	<b>252,580,887.41</b>
D0 2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
D0 3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			252,580,887.41	252,580,887.42
<b>D0 8</b>	<b>Тайлант үеийн үр дүн</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>(17,161,541.30)</b>	<b>(17,161,541.40)</b>
<b>D0 9</b>	<b>2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>			<b>235,419,346.11</b>	<b>235,419,346.12</b>

Булган аймаг дахь Төрийн аудитын газар

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
<b>2</b>	<b>I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>496,741,400.00</b>	<b>471,743,929.76</b>	<b>24,997,470.24</b>	<b>95.0</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>496,741,400.00</b>	<b>471,743,929.76</b>	<b>24,997,470.24</b>	<b>95.0</b>
<b>210</b>	<b>Бараа, үйлчилгээний зардал</b>	<b>495,826,200.00</b>	<b>470,828,929.76</b>	<b>24,997,270.24</b>	<b>95.0</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>364,683,400.00</b>	<b>364,683,399.65</b>	<b>0.35</b>	<b>100.0</b>
210101	Үндсэн цалин	308,944,600.00	289,101,096.69	19,843,503.31	93.6
210102	Нэмэгдэл	47,290,800.00	68,398,203.46	(21,107,403.46)	144.6
210103	Унаа, болон бусад нөхөн олговор	8,448,000.00	7,184,099.50	1,263,900.50	85.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>55,935,500.00</b>	<b>54,693,976.73</b>	<b>1,241,523.27</b>	<b>97.8</b>
210201	Тэтгэврийн даатгал	47,928,200.00	44,564,737.73	3,363,462.27	93.0
210202	Тэтгэмжийн даатгал	1,697,400.00	2,347,371.72	(649,971.72)	138.3
210203	ҮОМШӨ ний даатгал	2,349,300.00	2,589,638.21	(240,338.21)	110.2
210204	Ажилгүйдлийн даатгал	565,800.00	568,093.64	(2,293.64)	100.4
210205	Эрүүл мэндийн даатгал	3,394,800.00	4,624,135.43	(1,229,335.43)	136.2
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>27,844,800.00</b>	<b>24,463,382.98</b>	<b>3,381,417.02</b>	<b>87.9</b>
210301	Гэрэл цахилгаан	1,470,900.00	1,008,949.38	461,950.62	68.6
210302	Түлш, халаалт	26,373,900.00	23,454,433.60	2,919,466.40	88.9
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>14,324,900.00</b>	<b>14,282,640.40</b>	<b>42,259.60</b>	<b>99.7</b>
210401	Бичиг хэрэг	7,016,500.00	7,006,500.00	10,000.00	99.9
210402	Тээвэр (шатахуун)	2,613,100.00	2,606,600.00	6,500.00	99.8
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	1,970,400.00	1,970,340.40	59.60	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	50,700.00	25,000.00	25,700.00	49.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	2,674,200.00	2,674,200.00	-	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил худалдан авах</b>	<b>22,976,200.00</b>	<b>2,925,800.00</b>	<b>20,050,400.00</b>	<b>12.7</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	21,871,200.00	1,896,500.00	19,974,700.00	8.7
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	687,300.00	687,300.00	-	100.0
210604	Урсгал засвар	417,700.00	342,000.00	75,700.00	81.9
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>87,400.00</b>	<b>-</b>	<b>87,400.00</b>	<b>-</b>
210702	Дотоод албан томилолт	87,400.00	-	87,400.00	-

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр</b>	<b>1,696,400.00</b>	<b>1,512,650.00</b>	<b>183,750.00</b>	<b>89.2</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	814,800.00	807,500.00	7,300.00	99.1
210802	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	680,000.00	540,000.00	140,000.00	79.4
210803	Даатгалын үйлчилгээ	100,800.00	64,350.00	36,450.00	63.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,800.00	100,800.00	-	100.0
<b>2201</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>8,277,600.00</b>	<b>8,267,080.00</b>	<b>10,520.00</b>	<b>99.9</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,673,400.00	7,673,400.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	604,200.00	593,680.00	10,520.00	98.3
	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>915,200.00</b>	<b>915,000.00</b>	<b>200.00</b>	<b>100.0</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	915,200.00	915,000.00	200.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	915,200.00	915,000.00	200.00	100.0
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>24,824,000.00</b>	<b>(24,824,000.00)</b>	<b>-</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>-</b>	<b>24,824,000.00</b>	<b>(24,824,000.00)</b>	<b>-</b>
222001	Тоног төхөөрөмж	-	5,000,000.00	(5,000,000.00)	-
223001	Бусад хөрөнгө	-	19,824,000.00	(19,824,000.00)	-
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>469,699,718.20</b>	<b>(462,026,318.20)</b>	<b>6.12</b>
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	489,068,000.00	(489,068,000.00)	-
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	489,068,000.00	(489,068,000.00)	-
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	(32,041,681.80)	32,041,681.80	-
120004 1	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	(32,041,681.80)	32,041,681.80	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,673,400.00	12,673,400.00	(5,000,000.00)	165.2
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,673,400.00	12,673,400.00	(5,000,000.00)	165.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	30.00	30.00	-	100.0
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	25.00	25.00	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	4.00	4.00	-	100.0

Булган аймаг дахь Төрийн аудитын газар

## **САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

#### ***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Улсын бүртгэлийн хэлтэс нь аймгийн хэмжээнд хуульд заасан иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн зарим төрлийн бүртгэлийг эрхлэн хөтлөх, бүртгэлтэй холбоотой үйлчилгээг иргэдэд үзүүлэх, улсын бүртгэлийн гэрчилгээ, үндэсний энгийн гадаад паспорт олгох, тэдгээдийн хүчинтэй байдлыг сунгах, хүчингүй болгох, сумын улсын бүртгэгч нарын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэгтэй.

УБЕГ-аас өгсөн удирдамж чиглэлийн дагуу иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйл ажиллагааг орон нутагт эрхлэн зохион байгуулж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, улсын бүртгэлийн шат дамжлагыг багасгаж, үйлчилгээг цахимжуулах замаар бүртгэлийн үйлчилгээг ил тод болгож, иргэдэд түргэн шуурхай хүргэх зорилт тавин ажиллаж байна.

### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус байгууллага нь Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль зэрэг бусад хууль, тогтоомж, улсын бүртгэлийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна. Иймд төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлсон ч гүйцэтгэх үе шатанд хөрөнгийн тооллогын үйл ажиллагаанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагатай гэж үзсэн.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллагын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

УБЕГ-ын даргын баталсан улсын бүртгэлийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Энэ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 16,948.4 мянган төгрөгөөр буюу 6.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс үндсэн хөрөнгийн данс материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	19,824.0	19,824.0
Байгууллагаас авах авлага	-	19,824.0	19,824.0
Бараа материал	59,160.9	54,524.1	(4,636.8)
Үндсэн хөрөнгө	193,419.9	161,284.3	(32,135.6)
<b>Нийт хөрөнгө</b>	<b><u>252,580.9</u></b>	<b><u>235,632.4</u></b>	<b><u>(16,948.4)</u></b>
Өр төлбөр		213.1	213.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	252,580.9	235,419.3	(17,161.6)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b><u>252,580.9</u></b>	<b><u>235,632.4</u></b>	<b><u>(16,948.4)</u></b>

Тайлант оны эцэст 19,824.0 мянган төгрөгийн 16 ш архивын нягтруулсан шүүгээ худалдан авахаар “Лүндээ-Очир” ХХК-тай гэрээ байгуулж, 2023 оны 1-р улиралд нийлүүлэх болсонтой холбоотой авлага үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 54,524.1 мянган төгрөг болж 4,636.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны зарцуулалттай холбоотой байна.

Төсвийн хөрөнгөөр 22,470.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, УБЕГ-аас 9,448.6 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авч тайлант хугацаанд 30,055.6 мянган төгрөгийн материал зарцуулжээ. УБЕГ-аас хуваарилсан 6,500.0 мянган төгрөгийн халуун хэмжигч төхөөрөмжийг бараа материалын дансанд бүртгэснийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлж 54,524.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болжээ.

Үндсэн хөрөнгө дансны хувьд УБЕГ-аас 1,915.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж хүлээн авч, 25,705.2 мянган төгрөгийн хөрөнгө акталж, 40,382.3 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаар оны эцэст 161,284.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 235,419.3 мянган төгрөг болж 17,161.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

Байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 63,230.5 мянган төгрөгөөр буюу 13.9 хувиар нэмэгдэхэд урсгал үйл ажиллагааны санхүүжилт 148,729.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө 32,122.5 мянган, нэмэлт санхүүжилтийн орлого 53,376.0 мянган төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлжээ.

Урсгал зардал өмнөх оноос 110,922.4 мянган төгрөгөөр өсчээ. Цалин, хөлс НДШ 117,557.1 мянган төгрөгөөр өсч, бараа үйлчилгээний бусад зардал 26,597.1 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

### **3.5. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Улсын бүртгэлийн хэлтэс 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 515,432.7 мянган төгрөгөөр тооцон төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг 409,025.8 мянган төгрөгөөр баталж, 106,406.9 төгрөгөөр бууруулсан байна. Тайлант онд дээрх төсөвт өөрчлөлт оруулж, 80,042.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, оны эцэст 489,068.0 мянган төгрөгөөр тодотгон баталжээ.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр 489,068.0 мянган төгрөгийг улсын төсвөөс баталж, орон нутгийн нөөц хөрөнгөөс 5,000.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 7,673.4 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилжээ.

Гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь олгож, зарцуулаагүй үлдэгдэл 5,173.5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 471,743.9 мянган төгрөг буюу 95.0 хувьтай байгаа нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 3,381.4 мянга, цалин, ажил олгогчоос төлөх НДШ 1,241.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлээр гаргаагүй нь УСНББОУС-1, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4-т заасан бүрэлдэхүүн хэсэг: гэсэнтэй нийцэхгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн Засаг даргын нөөц сангаас “D KIOSK” машин тоног төхөөрөмж худалдан авахад хуваарилсан 5,000.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчаас сонгуулийн үйл ажиллагааны зардалд 7,673.4 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг төвлөрүүлж, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгах, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “ЦЭСБ аудит” ХХК-ийн аудитор Ш.Ганчимэг, аудиторын туслах Б.Бүжингоо нар гүйцэтгэж, хяналтыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Улсын бүртгэлийн хэлтэс 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 37 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 489,068.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 4,890.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажилласан ч 380.0 мянган төгрөгөөр ажилтны дүрэмт хувцас худалдсан авсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Дээрх хуулийн хүрээнд батлагдсан төсөв 5,173.5 мянган төгрөгөөр зарцуулагдаагүй, төвлөрүүлсэн нь байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, ажил олгогчоос төлөх НДШ зарцуулагдаагүй үлдсэнтэй холбоотой байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.6-д заасан 1 мэдээлэлийг хугацаа хоцроосон, 6 дугаар зүйлийн 6.1.5-д заасан аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг мэдээлээгүй байна.

#### Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах, алдааг давтан гаргасан тул хэрэгжүүлж ажиллах тухай албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	1	87.5	1	87.5	100
Зөвлөмж	3	208.0	2	208.0	94.5
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>295.5</b>	<b>3</b>	<b>295.5</b>	<b>97.25</b>

Өмнөх аудитаар өгсөн 3 зөвлөмж, 87.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлж ажилласан ч шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийн биелэлт 94.5 хувьтай байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 11,120.8 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 2,269.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 380.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 5,000.0 мянган төгрөгийн албан шаардлага, 3,471.5 мянган төгрөгийн зөвлөмж өглөө.

### **5.1 Төлбөрийн акт**

Тус байгууллага 380.0 мянган төгрөгөөр ажилтны дүрэмт хувцас худалдсан авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байх тул төлбөрийн акт тогтоов.

### **5.2 Албан шаардлага**

1. Тайлант оны төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, үр дүнгээр тайлагнаагүй байна. Энэ нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга-санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн хэсгүүд, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна, 54.5.4-т хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга гэж заасныг хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.6-д заасан 1 мэдээллийг хугацаа хоцроосон, аудитын тайлан, дүгнэлт, 295.5 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилтийг мэдээлээгүй нь дээрх хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалттай нийцэхгүй байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил давтагдан гарч байгаа тул албан шаардлага өгөхөөр шийдвэрлэсэн.

3. Орон нутгийн төсвийн 5,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан “D KIOSK” машин төхөөрөмжийг бараа материалын дансанд бүртгэснийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэх.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

#### Илрүүлэлт:

1. 570.0 мянган төгрөгийн шатахууныг тооцооны дансаар дамжуулалгүй шууд зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө” гэсэн заалтыг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар бүртгэх

2. Тайлант хугацааны шатахууны зарцуулалт, жолоочийн тооцоо бодоогүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шатахууны зарцуулалтыг анхан шатны баримтанд үндэслэн зардалд бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн	Үүнээс					Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн		Залруулсан		Залруулаагүй			Тоо	Дүн	
					Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Арилжааны банк дахь харилцах дансны үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаагүй	1	2,269.3	1	2,269.3		1	2,269.3						
Дүн	1	2,269.3	1	2,269.3	-	1	2,269.3	-	-	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Дүрэмт хувцас худалдсан авсан	1	380.0	1	380.0								
Төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэлээр тайлагнаагүй	1		-	-	1			-		-	-	-
D KIOSK төхөөрөмжийг бараа материалын дансанд бүртгэсэн	1	5,000.0			1	5,000.0						

